



**ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ**

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2023 оны эхний хагас жилийн байдлаар/**

Улаанбаатар хот, 2023 он

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2023 оны эхний хагас жилийн байдлаар/**

2023 оны 07 дугаар сарын 06

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго:

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэр зэрэг эрүүл мэндийн салбартай холбоотой хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, хүлээгдэж буй үр дүндээ хүрч байгаа эсэхийг нягтлах, эрхзүйн баримт бичгийн заалт тус бүрийн хэрэгжилтийг хянах, үнэлэх, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарт мэдээлэл өгөхөд оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.3 дахь заалтад заагдсан аргачлалыг баримтлан биелэлтийн хувиар тооцон үнэлгээг хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн:

2023 оны эхний хагас жилийн байдлаар Эрүүл мэндийн салбарт нийт 113 шийдвэрийн 270 заалт бүхий арга хэмжээ хяналтад авагдсан байна. /Хүснэгт 1/

	Нийт	Монгол Улсын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ҮАБЗ-ийн н зөвлөмж
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	113	16	10	12	5	19	43	4	4
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	270	78	41	28	9	23	73	5	13

2023 оны эхний хагас жилийн байдлаар эрүүл мэндийн салбараас хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 72.19 хувьтай байна. /Хүснэгт 2/

Хэрэгжилт гаргах нийт заалтын тоо		270
Бүрэн хэрэгжсэн	100%	116 (43.0%)
Хэрэгжих шатанд	70%	65 (24.0%)
Хэрэгжилт хангалтгүй	30%	56 (20.7%)
Хэрэгжээгүй	0%	10 (3.7%)
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	23 (8.5%)
Хэрэгжилтийн дундаж		72.19%

Үүнээс бүрэн хэрэгжсэн 100 хувийн үнэлгээтэй 116 заалт (43.0%), хэрэгжих шатанд 70 хувьтай 65 заалт (24.0%), хэрэгжилт хангалтгүй 30 хувьтай 56 заалт (20.7%), хэрэгжээгүй буюу 0 хувийн хэрэгжилттэй 10 заалт (3.7%), хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 23 заалт (8.5%) байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт. /Хүснэгт 3/

№	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	Нийт	Бүрэн хэрэгжсэн (100 хувь)	Хэрэгжих шатанд (70 хувь)	Хэрэгжилт хангалтгүй (30 хувь)	Хэрэгжээгүй (0 хувь)	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Үнэлгээний хувь
1.	Монгол Улсын хууль	16 хуулийн 78 арга хэмжээ	54	10	9	3	2	83.82
2.	УИХ-ын тогтоол	10 тогтоолын 41 заалт	20	6	10	1	4	73.51
3.	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	12 тогтоолын 28 заалт	5	8	7	1	7	60.48
4.	Ерөнхийлөгчийн зарлиг	5 зарлигийн 9 заалт	7	-	1	1	-	81.11
5.	ҮАБЗ-ийн зөвлөмж	4 зөвлөмжийн 13 заалт	1	10	1	1	-	63.85
6.	Засгийн газрын тогтоол	19 тогтоолын 23 заалт	10	2	6	2	3	66
7.	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	43 тэмдэглэл 73 заалт	17	28	20	1	7	64.55
8.	ЗГ-ын албан даалгавар	4 албан даалгаврын 5 заалт	2	1	2	-	-	66
		270 заалт	116	65	56	10	23	72.19

Хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн хэрэгжилт /Хүснэгт 4/:

Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Тайланд тусгагдсан заалтын дугаар Хариуцсан газар
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ			
1.	Агаарын тухай 2012-05-17 Дугаар 2012.05.17	21.4. Суурин газрын агаар хамгаалах зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож хүн амын суурьшлын бүсээс зааглах бөгөөд уг бүсийн хэмжээг үйлдвэрлэл, үйлчилгээний салбар, төрөл бүрээр тогтоосон жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална	1/1 НЭМГ
2.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай 2012-12-20 Дугаар 2012.12.20	7.2. Хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршлаас хамаарч энэ хуулийн 7.1-д заасан зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална./7.1.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь өөрийн үйл ажиллагааны төрлөөс хамааран энэ хуулийн 4.1.19-4.1.21-д заасан дараах зохистой дадлыг нэвтрүүлнэ:7.1.1.хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал;7.1.2.хүнсний сүлжээний бүх үе шатанд эрүүл ахуйн зохистой дадал;7.1.3.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн шатанд үйлдвэрлэлийн зохистой дадал.	2/2 НЭМГ
3.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-07-08 Дугаар 2015.09.01	11.2. Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	3/3 ЭТҮГ
4.	Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай 2017-05-12 Дугаар 2017.05.12	15.3. Эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	6/11 ЭТҮГ
5.	Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай	1.4. Албадан эмчлэх эмнэлэг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг байх ба түүнийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэрийг Засгийн газар гаргана.	10/19 ЭТҮГ

	/Шинэчилсэн найруулга/ 2018-11-15 Дугаар 2019.01.01		
6.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай 2019-05-30 Дугаар 2019.05.30	10.4.1. Сургуулийн хүүхдийн хоол тэжээлийн байдлын судалгааг таван жил тутамд гаргаж, үр дүнг холбогдох төрийн байгууллага болон нийтэд мэдээлэх; (10.4.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	11/21 НЭМГ
7.	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01	15.7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, эрүүл мэнд, соёл, спортын байгууллага, оюутан, сурагчдын хичээлийн болон дотуур байрны байршил, аймаг, нийслэлийн саналыг харгалзан хүнс, эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно.	16/76 НЭМГ
8.		12.3. Согтууруулах ундааны шошгонд тавигдах шаардлага, анхааруулгын загварыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	16/76 НЭМГ
9.		14.1. Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтыг эрүүл мэндийн болон хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.	16/78 НЭМГ
10.	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06 Дугаар 2019 №62	1.4/б/. эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны сургалтын хөтөлбөрийн багцад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай сургалтыг оруулж, үе шаттайгаар зохион байгуулах;	17/79 ТЗУГ
11.	Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 2021-01-22 Дугаар 2021 №12	4. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг жил бүрийн намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хуралд хүргүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.	20/89 БТГ
12.		ЭМЯ хуулийн төсөл 2021. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Эх, хүүхдийн эрүүл мэндийн тухай Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль	20/90 БТГ, ЭТҮГ

13.		ЭМЯ хуулийн төсөл 2022. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай Цусны донорын тухай Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	20/91 ЭТҮГ, НЭМГ, ТЗУГ
14.	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021-07-07 Дугаар 2021 №67	1.1.а/. Улсын онцгой комиссоос цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр хүний эрх, эрх чөлөөнд тодорхой хязгаарлалт хийх аливаа шийдвэр гаргахдаа Хүний эрхийн Үндэсний Комиссоос санал авах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, Улсын онцгой комиссын хуралдаанд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнийг оролцуулж байх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)	21/92 ТЗУГ, НЭМГ
15.	Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай 2022-01-14 Дугаар 2022 №1	1.3/. Хүний генетикийн оношилгоо, эмчилгээ, генийн сангийн аюулгүй байдлыг зохицуулах чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд 2023 онд багтаан өргөн мэдүүлэх;	22/106 БТГ
16.	Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай 2022-01-14 Дугаар 2022 №1	1.4/. Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр орчин үеийн дэвшилтэт технологи бүхий генетикийн лаборатори, генийн сан байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх, шаардагдах төсвийг улсын төсвөөс санхүүжүүлэх;	22/107 БТГ
17.	Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай 2022-01-14 Дугаар 2022 №1	1.7/. Хүн амын өсөлт, нөхөн үржихүй, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор жирэмсэн эмэгтэй, эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ, асаргаа сувилгааны чанар, хүртээмжийг сайжруулах, хүүхдийн тооноос хамааруулан гэр бүлд дэмжлэг үзүүлэх талаар холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	22/110 ЭТҮГ
18.	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2022-07-06 Дугаар 2022 №49	б.а/. шинээр орон сууцны хороолол ашиглалтад орж байгаа болон хөдөө орон нутгаас шилжин суурьших иргэдийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулж өрхийн эрүүл мэндийн төвийн ачаалал нэмэгдэх, эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмжид нөлөөлж байгаа асуудалд үр дүнтэй хариу арга хэмжээ авч, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, өрхийн эрүүл мэндийн төвгүй хороо, суурин газарт стандартын шаардлага хангасан өрхийн эрүүл мэндийн төв байгуулах, өргөжүүлэх ажлыг эрчимжүүлэх; (6/Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар:)	24/112 ЭТҮГ, СЭЗГ
19.	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2022-07-06 Дугаар 2022 №49	б.в/. сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудалтай холбоотой сэтгэцийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, санхүүжилтийг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар зорилтот хөтөлбөр боловсруулах. (6/Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар:)	24/114 НЭМГ

УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ			
20.	Эрүүл мэндийн бодлого, эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2017-05-12 Дугаар 2017 №22 НББСШУБХ	2.. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс хийх ажлын төлөвлөгөө гаргаж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгахыг БСШУС-ын сайд, Сангийн сайд, ХНХ-ын сайд, ЭМ-ийн сайд нарт даалгасугай.	27/120 БТГ
21.	Хүүхдийг тамхины хор хөнөөлөөс сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-11 Дугаар 2022 №06 БСШУСБХ	1.1/. Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, бүх шатны боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг дам тамхидалтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хамгаалах арга хэмжээ авах;	33/130 НЭМГ
22.		1.2/. насанд хүрээгүй иргэнийг тамхины хор хөнөөлөөс хамгаалах, хүн амын тамхины хэрэглээг бууруулах зорилгоор импортоор оруулж байгаа болон Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэж байгаа тамхины доторх хорт бодисын агууламжийг харгалзан шаталсан хэлбэрээр төрөл тус бүрд онцгой албан татвар ногдуулдаг байх эрх зүйн орчныг бүрдүүлэх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх;	33/131 НЭМГ, БТГ
23.		1.3/. холбогдох хууль тогтоомжид электрон тамхи болон бусад шинэ төрлийн тамхи тус бүрийн тухай ойлголтыг тодорхойлж, түүний хэрэглээг зохицуулахтай холбоотой эрх зүйн одоогийн зохицуулалтуудад холбогдох нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;	33/132 БТГ
24.	Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ	1.11. Ахмад настны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яамны хамтын ажиллагааг эрчимжүүлэх.	34/136 ЭТҮГ
25.	Чиглэл өгөх тухай 2023-03-28 Дугаар 2023№05 НББХ	1.1.5/. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хамтран баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, маягт, шинэчлэн батлах тухай тушаалын хэрэгжилтийг хангуулах хүрээнд “Тусгай хэрэгцээт хүүхдийн эрт дэмжлэгийн нөхцөл байдлын үнэлгээ”, хүүхэд бүрийг хүчирхийлэлд өртөхөөс өмнө хийх багш, сургууль, цэцэрлэгийн нийгмийн ажилтанд суурилсан “Хүчирхийлэлд өртөж болзошгүй байдлын үнэлгээ”-г боловсруулах ажлын хэсгийг тус 3 яамны төлөөллийг	36/140 ЭТҮГ

		оролцуулан байгуулах, үнэлгээг 2023 оны 03 дугаар улиралд багтаан боловсруулах;	
26.	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-25 Дугаар 2023№05 ТБХ	За/. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, өмч хөрөнгийн бүртгэл, хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах, хэрэгжиж дууссан төслүүдийн хүрээнд үүссэн өмч, хөрөнгийн бүртгэлийг судлах, зээлийн эргэн төлөлтийн байдал, шинээр авахаар төлөвлөж буй зээлүүдийн эрэлт хэрэгцээг үнэлж, дүн шинжилгээ хийх, үр дүн муутай, хэрэгжилт удаашралтай төслүүд болон шинээр авахаар төлөвлөж буй шаардлагагүй гэж үзсэн зээлийг зогсоох, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг салбар бүрээр гаргах, танилцуулах;	37/144 СЭЗГ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
27.	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	39/148 ТЗУГ
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ			
28.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05	1.7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч, донтогчдын талаарх судалгааг гаргах, тэднийг албандан эмчлэх эмчилгээний арга зүй, стандартыг тогтоож, мэргэшсэн эмч, сэтгэл зүйч бүхий наръологийн төвийг байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх.	47/169 ЭТҮГ
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ			
29.	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай. 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;	49/172 ТЗУГ

		5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	
30.	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай.	55/178 БТГ, ТЗУГ
31.	Төслийн жагсаалт шинэчлэн батлах тухай 2022-12-07 Дугаар 2022_442	2. Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд 2019 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд 300 сая ам.доллартой тэнцэх зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. 2. Энэ тогтоолын хавсралтад заасан төслийг хэрэгжүүлэх талаар Европын сэргээн босголт, хөгжлийн банктэй тохиролцож, холбогдох гэрээ хэлэлцээрийг байгуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд, төслийг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд тус тус даалгасугай.	56/179 СЭЗГ
32.	Дэлхийн банкны цахим эрүүл мэнд төслийн санхүүжилтийн талаар авах арга хэмжээний тухай 2023-03-07 Дугаар 2023_89	1. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Цахим эрүүл мэнд төсөл”-ийн “Эрүүл мэндийн мэдээлэл солилцооны платформ”-ын ажлын гүйцэтгэгч “Taihan cable & Solution Co,Ltd” компанид төлсөн нийт 1,718,360.0 (нэг сая долоон зуун арван найман мянга гурван зуун жаран сая) ам.доллараас урьдчилгаа төлбөрт төлсөн 557,000.0 (таван зуун тавин долоон мянган) ам.долларыг гүйцэтгэгч компанийн арилжааны банкаар гаргуулсан гүйцэтгэлийн баталгааг гүйцэтгэх замаар улсын төсөвт төвлөрүүлэх шуурхай арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Сангийн сайд Б.Жавхлан нарт үүрэг болгосугай.	65/189 СЭЗГ
33.		2. Төслийн гүйцэтгэгч “Taihan cable & Solution Co,Ltd” компанид төлсөн санхүүжилтийн үлдэгдэл төлбөр болох 1,161,360.0 (нэг сая нэг зуун жаран нэгэн мянга гурван зуун жаран сая) ам.долларыг 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор эргүүлэн төлүүлэх шаардлагатай арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасугай.	65/190 СЭЗГ
34.	Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай	2. Засгийн газраас хэрэгжүүлж байгаа халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн	66/191 НЭМГ

	2023-03-29 Дугаар 2023_111	сургалтын байгууллагын өдрийн ангид суралцагчийг хамруулах арга хэмжээ авч, холбогдох зардлыг төсвийн ерөнхийлөгч захирагчийн 2023 оны батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд тооцож санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нарт тус тус даалгасугай.	
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ			
35.	2021 оны 3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14	ХII.2.2. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан хууль тогтоомжийн төслийг боловсруулах ажлын төлөвлөгөөг баталж, үндсэн чиглэлд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;	68/195 БТГ, ЭТҮГ, НЭМГ
36.	2021 оны 5 дугаар сарын 5-ны өдөр 28 дугаар тэмдэглэл 2021-05-05 Дугаар 2021_28	ХХIII.2.2. Нийслэлийн Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барих асуудлын талаар Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Эмнэлгийн төлөвлөлтийг олон улсын жишигт нийцүүлэн цогцоор нь иж бүрэн төлөвлөх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар нарт;	70/198 СЭЗГ
37.	2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2021-07-07 Дугаар 2021_41	ХХVII.7. . Төлбөрийн чадваргүй болсны улмаас албадан татан буугдсан “Капитал банк”-д байршиж байсан Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг буцаан төвлөрүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан албадан татан буугдсан “Капитал банк”-аас Эрүүл мэндийн даатгалын сангийн нэхэмжилж байгаа өр төлбөрт банкны эрх хүлээн авагчаас санал болгож буй хөрөнгийг тооцож авах асуудлаар эрх бүхий холбогдох байгууллагын үнэлгээ, мэргэжлийн дүгнэлтэд үндэслэн шаардлагатай арга хэмжээг зохих журмын дагуу авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга С.Энхболдод даалгав.	77/199 СЭЗГ
38.	2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2021-08-25 Дугаар 2021_48	ХҮI.4. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд хамруулах арга хэмжээний талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдахыг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод даалгав.	74/203 НЭМГ
39.	2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 58 дугаар тэмдэглэл	ХII.6.8. Дээр дурдсан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, улс, орон нутгийн жил бүрийн төсвийн төсөлд тусгах, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан,	79/208 СЭЗГ

	2021-11-03 Дугаар 2021_58	Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.	
40.	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	83/214 БТГ
41.	2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр 33 дугаар тэмдэглэл 2022-06-15 Дугаар 2022_33	XIII.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, өнөөгийн нөхцөл байдлын талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хяналт тавих, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг зохих журмын дагуу дэмжиж ажиллах; 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны 34 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, хамгаалах хүрээнд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт тавьж ажиллах.	85/216 ЭТҮГ
42.		XIII.1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сайжруулах хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод даалгав: 2.1. тархины саа, саажилт, уналт таталттай хүүхдийн уналт таталтын эсрэг эм хангамжийн нөхцөл байдлыг судалж, шаардлагатай эм, бэлдмэлийг бүртгэлжүүлж, нэр төрлийг нэмэгдүүлэх, төлбөрийг	85/217 ЭТҮГ, БТГ, СЭЗГ

	<p>төрөөс хариуцах эмийн жагсаалтад оруулах, яаралтай горимоор хангах талаар холбогдох арга хэмжээ авах; 2.2. ховор тохиолддог өвчин, эмгэгийг эмчлэх болон гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед шаардагдах эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, эмнэлгийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийн худалдан авалт, ханган нийлүүлэлт, нөөц, бэлэн байдлын асуудал хариуцсан байгууллагыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байгуулах эсэх асуудлыг судалж саналаа Засгийн газарт танилцуулах; 2.3. хүүхдийн өвчин, эмгэг, хавдар, хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн тархвар зүй, шалтгаан, хэрэгцээний талаар судалгаа хийж, өвчин, эмгэг, хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх, эмчийн хандлага, харилцаа, эмийн болон бусад эмчилгээг олон улсын түвшинд хүргэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 2.4. бүх шатанд хүүхдийн мэдрэлийн эмгэгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эмчилгээ, үйлчилгээний үр дүнг үнэлэх, нарийн мэргэжлийн эмчийг чадавхжуулах талаар зохих арга хэмжээ авах; 2.5. Монгол Улсад эмчлэх боломжгүй хүүхдийн өвчин, эмгэгийг гадаадын эмчилгээний багтай хамтран эх орондоо эмчлэх боломж, нөхцөлийг судалж, мэс засал яаралтай хийлгэх шаардлагатай зарим хүүхдийн асуудлыг 2022 оны 9 дүгээр сард багтаан нэн тэргүүнд шийдвэрлэх, эмчилгээний арга технологийг нутагшуулах замаар эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах; 2.6. хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, эмчлэх, сувилах, сэргээн засахад шаардлагатай хүний нөөц, оношилгооны лаборатори, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо судалгааг гаргаж, шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах.</p>	
43.	<p>XIII.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж, хөгжлийн үйлчилгээг сайжруулахтай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгав: 4.1. байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч, ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа эцэг, эсхүл эх, хууль ёсны асран хамгаалагчийн эрүүл мэндийн даатгалын болон тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож улсын төсвөөс төлөх боломжийг судлан саналаа шаардагдах зардлын тооцооллын хамт танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл</p>	85/218 ЭТҮГ, БТГ, СЭЗГ, ТЗУГ

		<p>мэндийн сайд С.Энхболд нарт; 4.2. Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр болон эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмжийн хэмжээг 288,000 төгрөгөөр үргэлжлүүлэн олгох болон цаашид уг хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх боломжтой эсэхийг судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа нарт; 4.3. хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд шаардлагатай хүний нөөцийн судалгааг хийж, дутагдалтай байгаа мэргэжилтнийг 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн үе шаттайгаар бэлтгэх, сургалтын орчин, материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.4. хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтний урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг судалж, шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.5. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийг хүүхдээ асрах, хөгжүүлэх, дэмжих чиглэлийн богино хугацааны сургалтад хамруулж, энэ чиглэлээр хөдөлмөр эрхлэх, цаашид мэргэжил эзэмшихэд нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.6. хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийг үнэлэх Үйлдлийн олон улсын ангилал (ICF)-ыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.7. эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчгүй, байнгын асаргаа шаардлагатай сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй, оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн асрамжийн газрыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дэргэд байгуулах асуудлыг судалж, шаардагдах санхүүжилтийг Монгол Улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.8. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн эрүүл мэнд, сэргээн заслын цогц тусламж, үйлчилгээг өргөжүүлж, мэргэжил, арга зүй, хүний нөөц, эм хэрэгсэл, багаж, тоног</p>	
--	--	--	--

		төхөөрөмжөөр хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт; 4.9. харьяалах нутаг дэвсгэрийнхээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэндийн болон нийгмийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тэдний хөгжлийг дэмжих чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт, 4.10. бага орлоготой, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн гишүүнтэй өрхийн орон сууцны хангамж, нөхцөлийг судлан сайжруулах шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	
44.	2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2022-06-22 Дугаар 2022_34	XII.8.3. Улаанбаатар хотоос хөдөө рүү шилжин амьдрах асуудлыг дэмжих, орон нутагт амьдрахын давуу талыг сурталчлах, олон нийтийн нөлөөллийн арга хэмжээг өрнүүлэх асуудлыг хамтран судалж, саналаа танилцуулахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав.	86/219 БТГ, ТЗУГ
45.	2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр 41 дүгээр тэмдэглэл 2022-08-17 Дугаар 2022_41	YIII.7. . “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний биелэлтийн явцыг 2022 оны хагас жилийн байдлаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, холбогдох агентлагийн дарга нарт тус тус үүрэг болгов: 1. Биелэлт нь хангалтгүй байгаа 32 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж жилийн эцсийн зорилтот түвшинд хүргэх шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 2. Төсөл, арга хэмжээний биелэлтийг зарцуулсан хөрөнгийн хэмжээ, шалгуур үзүүлэлтийг хангасан байдал, хүрсэн үр дүн зэргийг тодорхой тусгаж бүрэн тайлагнаж байх.	89/223 СЭЗГ, БТГ, ЭТҮГ
46.	2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2022-10-05 Дугаар 2022_48	XII.1.2. Дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 2.1. Эрхлэх асуудлын хүрээнд стандарт, техникийн зохицуулалтын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; 2.2. “Үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 235 дугаар тогтоолын хэрэгжилтийг дүгнэж, салбарын шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг	91/226 ЭТҮГ

		2022 онд багтаан боловсруулж, батлуулахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд;	
47.	2023_8. 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдөр 8 дугаар тэмдэглэл / 2023-02-08 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ХХХҮ.11.1. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Цахим эрүүл мэнд” төслийн хэрэгжилтийн талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Цахим эрүүл мэнд” төслийн хэрэгжилт, үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулж, уг төслийг цаашид хэрэгжүүлэхгүй байх талаар санал солилцохыг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт үүрэг болгов;	100/241 БТГ
48.	2023_10. 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл / 2023-03-01 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ХҮ.4. Хүн амын дунд амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, шүдний өвчний тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, уг арга хэмжээнд хувийн эмнэлгүүдийг хамруулан оролцуулах талаар бодлогын арга хэмжээний санал боловсруулж, Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт даалгав.	102/249 НЭМГ
49.	2023_10. 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл / 2023-03-01 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ХҮ.8. Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хэмнэлттэй цахилгаан машиныг хэрэглэх талаар судлах, эрт босож хэвших, хоолны зөв хэрэглээ, амьдралын зөв хэмнэлд суралцах талаар нийгмийг уриалах, өглөөний уулзалтыг хийж хэвшүүлэх зэрэг асуудалд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд, дээрх асуудлуудтай уялдуулан цаг өөрчилснөөр эдийн засагт ямар нөлөө үзүүлэх талаар судалгаа, тооцоо хийж санал боловсруулж, танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар нарт даалгав.	102/250 НЭМГ
50.	2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11	ХII.2.1. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтын явц, амны хөндийн эрүүл мэндийн өнөөгийн байдлын талаар Эрүүл мэндийн сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хүн амыг эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх, аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийг дэмжих төвүүдийг ходоодны уян дурангийн аппаратаар нэмэлтээр хангахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	103/252 НЭМГ
51.		ХII.2.2. Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дэмжих, амьдралын эрүүл хэв маягийг төлөвшүүлэх, оюутан, суралцагчдын эрүүл мэндийн даатгалын	103/253 НЭМГ

		хамрагдалтыг нэмэгдүүлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдах боломжийг бүрдүүлэх чиглэлээр хамтарч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт	
52.		XII.2.3. Эрүүл мэндийн салбарын цахим системийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт;	103/254 БТГ
53.		XII.2.4. 2024 онд “Шүд” төсөл хэрэгжүүлэх, энэ хүрээнд Нүүр ам судлалын үндэсний төвийг байгуулах талаар судалж, танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзоригт;	103/255 НЭМГ
54.	2023_19. 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл / 2023-05-03 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	XVIII.3.2. Шаардлагатай мэдээлэл, тайланг бэлтгэхэд оролцох албан хаагчийг томилон ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав.	108/264 ТЗУГ
ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР			
55.	Бүтээн байгуулалтын төсөл, бодлогын зарим арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2021-09-15 Дугаар 2021_01	15.3. 15.3. Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төв, Зүрх судасны үндэсний төв, Түлэнхийн төв, Хавдар судлалын үндэсний төвийн барилгыг шинээр барих зураг төслийг боловсруулж, санхүүжилтийн шаардагдах эх үүсвэрийг тооцож Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгуулах саналаа танилцуулах.	109/266 СЭЗГ
56.	Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай 2022-07-04 Дугаар 2022_3	2. Энэ албан даалгаврын 1-д заасан төлөвлөгөөнд тусгах нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санал, зөвлөмжийг заавал авч байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	110/267 БТГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 2023 оны эхний хагас жилийн байдлаар эрүүл мэндийн салбараас хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн Хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн хэрэгжилттэй 56 арга хэмжээний давхардсан тоогоор 19 нь НЭМГ, 17 арга хэмжээ нь БТГазар, 15 арга хэмжээ ЭТҮГазар, 12 арга хэмжээ нь СЭЗГ, ТЗУГ-т 9 арга хэмжээ тус тус хамаарагдаж байна.

Хэрэгжээгүй буюу 0 хувийн хэрэгжилт /Хүснэгт 5/:

Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Тайланд тусгагдсан заалтын дугаар Хариуцсан газар
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ			
1	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай 2016-04-22 Дугаар 2016.04.22	15.22. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний урамшууллын жишиг хэмжээ, олгох журмыг санхүү, төсвийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	4/6 БТГ
2	Биеийн тамир, спортын тухай 2017-07-06 Дугаар 2018.01.01	19.3.. Энэ хуулийн 19.2-д заасан зарчмыг хангах зорилгоор улсын хэмжээний спортын тэмцээнд оролцох хөгжлийн бэрхшээлтэй тамирчны ангиллыг олон улсын дүрмийн дагуу тогтоох комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг биеийн тамир, спорт, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	7/13 НЭМГ
3	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.6.8. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	14/67 СЭЗГ
4	Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай 2022-01-14 Дугаар 2022 №1	1.5/. Монгол хүний удмын санг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох саналыг боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулах	22/108 БТГ
УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ			
5	Хүүхдийг тамхины хор хөнөөлөөс сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-11 Дугаар 2022 №06 БСШУСБХ	2. Энэ тогтоолын хэрэгжилтийн тайланг Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд 2022 оны 10 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.	33/134 НЭМГ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ			
6	Засгийн газарт чиглэл өгөх тухай	1.17. Хүний эрүүл мэндэд нөлөөтэй эмийн бус бүтээгдэхүүн /чихэр, давс, хансан тос ихээр агуулсан хүнс, зохицуулах үйлчилгээний хүнс,	41/153 НЭМГ

	2019-05-30 Дугаар 2019_104	биологийн идэвхт бүтээгдэхүүн, согтууруулах ундаа, тамхи/ -ийн тусгай зөвшөөрөл, бүртгэл, сав, баглаа боодол, шошгын танилцуулга, зар сурталчилгааг зохицуулах, хянах эрх зүйн зохицуулалтыг бий болгох.	
ҮАБЗ-ийн зөвлөмж			
7	Биоаюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2011-07-07 Дугаар 2011_25/24	1. Биоаюулгүй байдлыг хангах урт хугацааны цогц бодлого бүхий үндэсний хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлэх	45/159 НЭМГ
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ			
8	Цар тахлын эсрэг биобэлдмэл, вакцин үйлдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай 2021-05-12 Дугаар 2021_144	4. Шинэ үеийн биотехнологид суурилсан коронавирусын эсрэг вакцин үйлдвэрлэх технологийг дамжуулан авах ажлыг зохион байгуулахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт, түүнд шаардагдах зардлыг тухай бүр шийдвэрлэж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.	48/171 БТГ
9	Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2022-12-21 Дугаар 2022_469	4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зохих нэмэлт, өөрчлөлтийг тусган боловсруулж, батлуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай.	59/183 ТЗУГ
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ			
10	2021 оны 3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14	ХII.6. Хуримтлалын нэгдсэн сан байгуулах зорилтыг хэрэгжүүлэхээр зохион байгуулсан ажил, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хуримтлалын нэгдсэн сан байгуулах асуудлаар нэгдсэн ойлголтод хүрч, шаардлагатай эрх зүйн орчин, санхүүжилтийн эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлэх, цаашид хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулан иргэдийг орон сууцжуулах, тэтгэвэр, тэтгэмж, сургалтын тэтгэлэг олгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг иргэдийн нийгэм, эдийн засгийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хамтран судалж, зохих арга хэмжээ авч ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт даалгав.”	68/196 БТГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 2023 оны эхний хагас жилийн байдлаар эрүүл мэндийн салбараас хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн Хэрэгжээгүй буюу 0 хувийн хэрэгжилттэй 10 арга хэмжээний 4 арга хэмжээ БТГ, 4 арга хэмжээ НЭМГ, 1 арга хэмжээ СЭЗГ, 1 арга хэмжээ ТЗУГ-т хамаарагдаж байна.

Дүгнэлт, зөвлөмж:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 72.19 хувьтай байна.
- Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр эрүүл мэндийн салбараас хяналтад авсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд Үүнээс бүрэн хэрэгжсэн 100 хувийн үнэлгээтэй 116 заалт (43.0%), хэрэгжих шатанд 70 хувьтай 65 заалт (24.0%), хэрэгжилт хангалтгүй 30 хувьтай 56 заалт (20.7%), хэрэгжээгүй буюу 0 хувийн хэрэгжилттэй 10 заалт (3.7%), хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 23 заалт (8.5%) байна.
- 2023 оны эхний хагас жилд Эрүүл мэндийн салбар нийт 113 шийдвэрийн 270 заалт бүхий арга хэмжээ хяналтад авч, хэрэгжүүлсэн нь 2022 оны мөн үетэй харьцуулахад 3 шийдвэрийн 37 заалт бүхий арга хэмжээгээр цөөн байна.
- 2023 оны эхний хагас жилийн байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 72.19 хувьтай үнэлэгдэж байгаа нь өмнөх 2022 оны мөн үетэй харьцуулахад 5.61 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Хуулийн хэрэгжилтийг хангах тухай" А/262 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 2021-2024 онд боловсруулж, Засгийн газраар батлуулах журам, дүрэм, зааврын жагсаалт болон Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах шийдвэрийн жагсаалтын дагуу холбогдох арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай байна.
- Яамны харьяа эрүүл мэндийн 26 байгууллагаас 2023 оны эхний хагас жилийн байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлсэн.
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээс тогтмол хэрэгжүүлэх тул хяналтад авсан жагсаалтаас хасуулж, Эрүүл мэндийн яамны дотоод хяналтад авах 34 саналыг тайланд тусгасан.
- 2023 оны эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэл нь хангалтгүй, удаашралтай байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн шалтгааныг тодорхойлон хэрэгжилтийг эрчимжүүлэх, эзэнжүүлэх, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, тайлан бичилтийг сайжруулж чанаржуулах, газар, хэлтсүүд хоорондоо уялдаа холбоотой ажиллах, тайлант хугацааны арга хэмжээний үр дүнг нэмэгдүүлэн ажиллах чиглэлээр зөвлөмжийг яамны харьяа эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэх.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР